



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2023 оны 01 сарын 06 өдөр

Дугаар A/01

Улаанбаатар хот

Тушаал хүчингүй болгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1 дэх хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн ордон доторх зоогийн газар, кофе шопын түрээслэгчийг дахин сонгон шалгаруулах болсонтой холбогдуулан ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/71 дүгээр тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга /Д.Нарангэрэл/-д даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ